

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 19 дүгээр тэмдэглэлд:

“6.ХЭЛЭЛЦСЭН нь: Төрийн өмчийн зарим их сургуулийн талаар авах арга хэмжээний тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1.Төрийн өмчийн зарим их сургуулийн талаар авах арга хэмжээний тухай асуудлыг хэлэлцээд тогтоол гаргахаар тогтв.

2.Үүнтэй холбогдуулан дараах асуудлыг судалж саналаа танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Соёлын сайд Ч.Номин нарт тус тус даалгав:

2.1.Монгол Улсын их сургуульд Бодлогын судалгааны лаборатори, Монгол Улсын их сургуулийн Баруун бүсийн сургуулийн дэргэд Баруун бүсийн судалгааны хүрээлэн байгуулах эсэх;

2.2.Хөдөө аж ахуйн их сургууль, түүний харьяа хүрээлэн, салбар, бүрэлдэхүүн сургуулийн нөөцөд тулгуурлан Хөдөө аж ахуйн шинжлэх ухаан, технологийн парк байгуулах боломжийг судлах, тус сургуулийн дотуур байрны засвар, сургалтын тоног төхөөрөмж, салбар дундын үйлдвэрлэл дадлагын баазыг бэхжүүлэх, багшийг чадавхжуулах асуудлыг судалж, саналаа шаардагдах эх үүсвэрийн тооцооллын хамт танилцуулах;

2.3.соёл, урлагийн байгууллагуудтай сургалт-үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг эрчимжүүлж, сургалт-судалгааны чадавхыг сайжруулах зорилгоор соёл, урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох санал боловсруулж танилцуулах.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

ШТА1206 9023100394 5498449